



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар

A/51

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 106 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нүүрс хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулж буй Ховд аймгийн Жаргалант сумын ард иргэдэд Хотгор, Тарвагатайн уурхайгаас хөнгөлөлттэй үнээр нүүрс нийлүүлэлтийн ажилд сан бүрдүүлэхэд 40 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх ажлын санхүүжилтэнд шаардагдах 40 000 000 /дөчин сая/ төгрөгийг "Ховд хөшөөт хөгжил сан"-гаас тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Ховд хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал /Т.Мягмардорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилт, санхүүжилтийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

